



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан Эрчим хүчний яамны үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



123006823
4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 он 02 дугаар сарын 2-ны өдрийн
24 дугаар тогтоолын хавсралт



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ
АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Үндсэн ангилал	Төрөл		Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин (туулах чадвар сайтай)		3
2		Хот доторх ажлын суудлын автомашин	суудлын	2
3			микробус	1
Нийт автомашин				6